Үнэт цаас гаргагч:

Bers ABS active

Андеррайтер:

MANDAL CAPITAL

# БЭРС

## ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААС

## ТАНИЛЦУУЛГА

Татан төвлөрүүлэх дүн
**10 тэрбум төгрөг**

Хүү /жилийн/
**16.8%**

Хугацаа
**24 сар**

Үндсэн төлөлт
**Жилд 1 удаа**

Хүүгийн төлөлт
**Улирал тутам**

Нэгжийн үнэ
**100,000₮**

Захиалгын хугацаа:
**2022.08.25 - 08.31**

#ХүүгээБэрсГарга

## КОМПАНИЙН ТУХАЙ

Бэрс Финанс ББСБ нь 2017 онд үүсгэн байгуулагдсан, Улаанбаатар хотод 2 салбар, орон нутагт 18 аймагт 19 салбар, нийт 21 салбартайгаар харилцагчдад санхүүгийн үйлчилгээг хүссэн газраасаа авах боломжийг бүрдүүлсэн **Монголын хамгийн өргөн дэд бүтэцтэй, хүртээмжтэй, хурдацтай өсөн тэлж буй банк бус санхүүгийн байгууллага** юм. 2021 онд 5.1 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, 2022 оны эхний хагас жилийн байдлаар 56 тэрбум төгрөгийн хөрөнгөтэй, 47 тэрбум төгрөгийн зээлийн багцтай болж, 7.4 тэрбум төгрөгийн хүүгийн орлоготой ажилласан байна.



*Бэрс Финанс ББСБ-ийн хамт олон*

## ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧИЙН ТУХАЙ

*Бэрс Финанс ББСБ ХХК-ийн байршил*





Бид харилцагчдынхаа хүсэл сонирхлыг мэдрэн, үргэлж хамгийн ойроос бүтээгдэхүүн үйлчилгээгээ хүргэж ажиллахыг зорьдог. 2015 оноос хойш хамгийн өргөн дэд бүтцээр өрхийн хэрэгцээг дэмжих, харилцагчдыг бизнестэй болгох, бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжин ажиллаж хэдийнээ 19 аймагт 21 салбараар дамжуулан 30,000 гаруй харилцагчдын санхүүгийн асуудлыг шийдээд байна. Харин одоо хямралын үед харилцагчдад тогтмол өндөр өгөөжтэй бүтээгдэхүүн болох ХБҮЦ-ийг санал болгож байна. Хамтдаа илүү ТОМ амжилтыг бүтээх болно.

**С.Отгонбат** | Бэрс Финанс ББСБ ХХК-ийн үүсгэн байгуулагч, Гүйцэтгэх захирал

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

**НИЙТ ХӨРӨНГӨ** | тэрбум төгрөг




**НИЙТ ЗЭЭЛ** | тэрбум төгрөг




**ХҮҮГИЙН ОРЛОГО** | тэрбум төгрөг




**ЦЭВЭР АШИГ** | тэрбум төгрөг




*Эх сурвалж: Бэрс Финанс ББСБ ХХК-ийн аудитлагдсан жилийн тайлан, аудитлагдаагүй улирлын тайлан*

БЭРС ХБҮЦ #ХүүгээБэрсГарга

## ЯАГААД БЭРС ХБҮЦ ГЭЖ?

Bers ABS active

Эдийн засаг саарч, өндөр инфляц бий болсон, зах зээл тогтворгүй энэ үед тогтмол өгөөжтэй бүтээгдэхүүн нь таны хөрөнгө мөнгийг найдвартай хамгаална. Тогтмол өгөөжтэй бүтээгдэхүүнээс эрсдэлийн түвшинг хамгийн бага байхаар бүтэцлэгдсэн бүтээгдэхүүн нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас (ХБҮЦ) юм.

**Хадгаламжийн хүү ба Инфляцын түвшин**




*Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Банкуудын веб хуудас*

Монгол Улсын хэмжээнд 2021 оны 05 сараас эхлэн хадгаламжийн жигнэсэн дундаж хүү инфляцтай тэнцэж ирснээр хадгаламжийн бүтээгдэхүүн бодит өгөөжгүй болж эхэлсэн.

2022 оны 06 сарын байдлаар Монгол Улсын инфляц 16.1 хувь, топ-5 банкны 24 сарын хугацаатай хадгаламжийн дундаж хүү 10.3 хувь буюу хадгаламжийн бодит өгөөж -5.8 хувь байна. Иймд мөнгөний үнэ цэнийг алдагдуулахгүйгээр өгөөж хүртэхийн тулд хөрөнгө оруулагчид 16.1 хувиас дээш түвшинд хөрөнгө оруулалт хийх шаардлага үүслээ. Бэрс ХБҮЦ нь тус боломжийг танд олгохоос гадна дараах онцлогтой:

### 1 16.8% ТОГТМОЛ ӨГӨӨЖТЭЙ

Банкны хадгаламж, компанийн бондтой ижил тогтмол өгөөжийг олгоно. Хадгаламжийн хүү хугацааны эцэст олгогддог бол ХБҮЦ нь улирал тутам хүүгийн орлогыг олгоно.

### 2 ТАТВАР 2 ДАХИН БАГА

Нээлттэй үнэт цаас тул тул хүүгийн орлогын татвар хадгаламж болон хаалттай бондоос 2 дахин бага буюу 5 хувь байдаг.

### 3 ЭРСДЭЛ БАГА

Эргэн төлөлтийн эх үүсвэр зээлийн багц нь 100% хэвийн зээлээс бүрдсэн. Тус зээлийн багцыг хөндлөнгийн хууль, санхүүгийн байгууллага, андеррайтераар эрсдэл бага гэдгийг баталгаажуулсан.

### 4 ХҮССЭН ҮЕДЭЭ ЗАРАХ БОЛОМЖТОЙ

Монголын Хөрөнгийн Бирж дээр үнэт цаасны компаниар дамжуулан хугацаанаас өмнө зарах боломжтой. Зарах тохиолдолд эзэмшсэн хоногоор хүүг 100% олгоно.

## ҮНЭТ ЦААСЖУУЛСАН ЗЭЭЛИЙН БАГЦЫН ТУХАЙ

**10** тэрбум төгрөг
ЗЭЭЛИЙН БАГЦ

**100%** Хэвийн
ЗЭЭЛИЙН ЧАНАР

**1,186** Зээлдэгч
ТӨВЛӨРӨЛ БАГА

*Тус зээлийн багц нь хуулийн шаардлага хангаж буй эсэхэд Өмгөөллийн Эм Ди Эс Энд Хаанлекс ХХН, санхүүгийн шалгуур хангаж буй эсэхэд Онч Аудит ХХК шинжилгээ хийж, шаардлагыг бүрэн хангасан гэж дүгнэсэн.*

## ЖИШИГ ТООЦООЛОЛ

### БЭРС ХБҮЦ

**Та 10,000,000 төгрөгийг Бэрс ХБҮЦ-д хөрөнгө оруулбал улирал тутам хүүний орлоготойгоос гадна 24 сарын хугацаанд 12,394,000 төгрөг /дахин хөрөнгө оруулалт хийвэл 13,192,000 төгрөгийг хүлээн авна.**

| Улирал | Үндсэн төлбөр | Татварын дараах хүүний орлого | Нийт орлого | Дахин хөрөнгө оруулалт хийвэл | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Хүүний орлого | Нийт |
| - | | | | | |
| 1 | | 399,000 | 399,000 | | 399,000 |
| 2 | | 399,000 | 399,000 | | 399,000 |
| 3 | | 399,000 | 399,000 | | 399,000 |
| 4 | 5,000,000 | 399,000 | 5,399,000 | | 5,399,000 |
| 5 | | 199,500 | 199,500 | 199,500 | 399,000 |
| 6 | | 199,500 | 199,500 | 199,500 | 399,000 |
| 7 | | 199,500 | 199,500 | 199,500 | 399,000 |
| 8 | 5,000,000 | 5,199,500 | 5,199,500 | 199,500 | 5,399,000 |
| **Нийт** | **10,000,000** | **2,394,000** | **12,394,000** | **798,000** | **13,192,000** |

### БАНКНЫ ХАДГАЛАМЖ

Та 10,000,000 төгрөгийг системийн топ-5 банкны хамгийн өндөр хүүтэй (10.5%) 24 сарын хугацаатай хадгаламжинд байршуулбал хугацааны эцэст 11,890,000 төгрөгийг хүлээн авна.

| Улирал | Үндсэн төлбөр | Татварын дараах хүүний орлого | Нийт орлого |
|---|---|---|---|
| - | | | |
| 1 | | | |
| 2 | | | |
| 3 | | | |
| 4 | | | |
| 5 | | | |
| 6 | | | |
| 7 | | | |
| 8 | 10,000,000 | 1,890,000 | 11,890,000 |
| **Нийт** | **10,000,000** | **1,890,000** | **11,890,000** |

## ЗАХИАЛГА ӨГӨХ ЗААВАР

**1**

### ҮНЭТ ЦААСНЫ ДАНС НЭЭЛГЭХ

Андеррайтер Мандал Капитал Маркетс ҮЦК болон бусад дурын үнэт цаасны компанид үнэт цаасны дансаа биетээр эсвэл онлайнаар нээлгэнэ.

**2**

### ЗАХИАЛГА ӨГӨХ

Өөрийн сонгосон үнэт цаасны компанид Бэрс ХБҮЦ худалдаж авах захиалга өгнө.
*Захиалга 100% дүүрэх үед хаагдахыг анхаарна уу.*

**3**

### МӨНГӨӨ БАЙРШУУЛАХ

Өөрийн нэрийн үнэт цаасны дансанд мөнгөө байршуулна. Дансны дэлгэрэнгүй мэдээллийг үнэт цаасны компаниас хүлээн авна.

**4**

### БАЯР ХҮРГЭЕ

Та Бэрс ХБҮЦ эзэмшигч боллоо.

MANDAL CAPITAL

8875-1110 | 8875-5251 | 7575-9911